

13

ГААЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТ**Ж.Батбаяр**


Орчин үеийн гаалийн байгууллага нь хүн, нийгэм, байгаль орчны аюулгүй байдлыг хамгаалах, барааны улс хоорондын хууль ёсны урсгалд учирч буй саад, тотгорыг арилгах үйлст хүчин зүтгэж, үүгээрээ улс орны хөгжил дэвшилд нэмэр болгохын төлөө ажиллаж байна. Энэ үүднээс гаалийн байгууллагын бүх шатны удирдлага болон салаа, мөчир болгонд бага хүчээр их амжилтанд хүрэх зорилт тавигдаж буйтай уялдан гаалийн ажлыг удирдан зохион байгуулах шинэлэг, дэвшилтэт арга технологи нэвтрүүлж, шинэ агуулгаар бяжсан стратеги төлөвлөгөө боловсруулан ажиллах шаардлага урган гарч байна. Иймд гаалийн байгууллагад эрсдлийг тооцож, тухайн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд хүч тэнцүүлэн ажилладаг оюунлаг хяналт /intelligent controls/-ын системийг аажмаар нэвтрүүлэх шаардлага нэгэнт бий болжээ.

Эрсдлийн менежментийг байгууллагын ажлын үр ашиг, үр нөлөөг шинжлэх ухааны үндэслэлтэй тоон илэрхийлэлд шилжүүлэн харуулах боломжийг бүрдүүлдэг тул түүнийг байгууллагын дотоод удирдлагын философи болгон мөрддөг байна. Эрсдлийн менежментэд эрсдлийн тооцоо гэсэн ойлголт багтаж байдаг бөгөөд энэ нь эрсдлийг таньж тогтоон, тоон илэрхийлэлд оруулах техник үйл ажиллагаа юм. Харин эрсдлийн менежментийн стратеги төлөвлөгөө нь аливаа байгууллагын ажлын үр дүнг дээшлүүлэх чухал хэрэгсэл билээ. Саяхан болтол эрсдлийн менежментийг зөвхөн үйл ажиллагаа нь бүрэн автоматжсан байгууллагад нэвтрүүлдэг гэсэн ташаа ойлголт байлаа. Тэгвэл тухайн байгууллага зөв сонголт хийж, хохирол багатай ажиллах боломжийг эрсдлийн менежмент бүрэлдүүлдэг учраас хөгжлийн ямарч түвшинд байгаа байгууллага, мөн шийдвэр гаргах аль ч шатанд стратеги, тактикийн зорилготойгоо уялдуулан нэвтрүүлэх боломжтой байдаг байна.

Эрсдэл нь бодлогын зорилтыг хэрэгжихгүй байдалд хүргэх боломж “аюул” мөн учраас менежментэд эрсдлийн асуудал чухал байр эзэлдэг. Аливаа эрсдэл нь дайсагнал, нөхцөл байдал, хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох, хүчин зүйлсийг тооцохдоо гаргасан алдаа болон хэрэгжүүлэх механизм, тэргүүлэх чиглэлийг буруу сонгох зэргээс болж үүсдэг. Иймээс эрсдэл үүсгэж байгаа шалтгаанаас нь үндэслэн дараах төрлүүдэд ангилж үзэж болно.

- **Улс төрийн** (улс төрийн чиг шугам солигдох, олон улсын хориг тавигдах г.м)
- **Хууль эрх зүйн** (олон улсын хууль тогтоомж болон гадаад худалдааны түнш орнуудын хууль тогтоомж өөрчлөгдөх, хууль эрх зүйн салбарт олон улсын байгууллагуудаас салангид байх)
- **Эдийн засгийн** (эрэлтийн нөхцөл, таваар, үйлчилгээний борлуулалтын хэмжээ, нөхцөл өөрчлөгдөх, үүний уршгаар хүлээснээс доогуур үр дүнд хүрэх)
- **Санхүүгийн** (татвар, зээл, төлбөрийн хувь хэмжээ өөрчлөгдөх)
- **Техникийн** (технологийн болон шинэ санаа, ёс суртахууны талын хоцрогдол)
- **Экологийн** (экологийн хохирол учруулах аюул)
- **Нийгмийн эрсдэл** (анхнаасаа тодорхой биш байсан эрсдэл, тогтворгүй байдлын эрсдэл, боломж алдаж уян хатан биш байсны эрсдэл, дур зоргоор аашлах, субъектив хандлагын эрсдэл г.м)

Эрсдлийг хооронд нь ялгалгүй, нэгэн адил хөндвөл ашиг, зардлын тооцоо алдагдах учир эрсдлийг тооцож зардал ашгийн тэнцвэрийг зөв олж тогтоох нь чухал. Иймд эрсдлийн зөвшөөрөгдсөн болон зөвшөөрөгдөөгүй хэмжээг зөв олж тогтоох шалгуур үзүүлэлтүүд байх ёстойг анхаарвал зохино. Эрсдлийг судалснаар эрсдэл үүсэх шалтгааныг илрүүлж дүн шинжилгээ хийх, эрсдлээс сэрэмжлэх, зорилтыг шийдвэрлэх боломжтой. Эрсдлийн менежментийн стратеги нь эрсдлийн нөхцөлтэй ажиллах, эрсдлийг хязгаарлах эсхүл урьдчилан сэргийлэх, эрсдлийг нөхөх зэрэг болно. Эрсдлийн менежментийг ерөнхий бүдүүвчээр харуулъя.



Эрсдлийн менежмент нь гаалийн байгууллагын хувьд гаалийн үндсэн үйл ажиллагаа болох хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, мөрдөж ажиллахад ямар нэг сөрөг нөлөө авчирч болзошгүй үр дагавар, түүний хэмжээ нэмэгдэх магадлалыг урьдчилан тооцож эрсдийг тодорхойлох, судалгаа хийн задлан шинжилж, үнэлгээ өгсөнөөр эрсдлийн түвшинг зөв тогтоож, учрах хохирол, үр дагаварыг бууруулах зорилготой зохион байгуулалт бүхий үйл ажиллагааны цогц арга хэмжээнүүдийг өөртөө багтаадаг. Өөрөөр хэлбэл эрсдлийн менежмент нь эрсдэл бүхий хөдөлгөөн, эсхүл ачаанд хяналт тавих үүднээс гаалийн байгууллагыг холбогдох мэдээллээр хангах менежментийн арга ажиллагаа, практикийг үйл ажиллагаандаа хэвшүүлэн хэрэгжүүлэх явдал юм. Эрсдлийн менежментийг гаалийн байгууллагад хэрэгжүүлэх эрх зүйн үндэс нь шинэчлэн батлагдсан Киотогийн конвенци түүний ерөнхий хавсралтын 6 дугаар бүлгийн стандарт заалт юм. Аль ч орны гаалийн байгууллага улсын хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд хяналт тавин ажиллах замаар хууль сахиулах үндсэн үүрэгтэй. Иймд эрсдлийн менежментийг байгууллагын дотоод удирдлагын философи болгон хэрэгжүүлсэнээр гаалийн байгууллагын үндсэн үүрэгт ажлын үр ашиг, нөлөө эрс дээшилж, дотоод нөөцийн зөв хуваарьтай, хэмнэлттэй ажиллах боломж нээгдэнэ гэдгийг ДГБ-аас онцлон тэмдэглээд, гаалийн байгууллагад эрсдлийн менежмент хэрэгжүүлэхийн ашиг тусыг дараах байдлаар тоймлон үзүүлжээ. Үүнд:

- Гаалийн байгууллагын улмаар засгийн газрын зорилго биелнэ.
- Гаалийн удирдлагын арга ажиллагаа сайжирна.
- Нийгэм, бизнесийн чиг хандлагын тодорхойлолт боловсронгуй болно.
- Гаалийн ажилтны оюунлаг хандлага хөгжиж, нарийн мэргэшинэ.
- Гаалийн байгууллага байгаа нөөц бололцоогоо гүйцэд ашиглаж, бага хүчээр ихийг бүтээнэ.
- Эрсдэл өндөртэй цэгт гол хүч төвлөрнө.
- Хууль чёны худалдаа өргөжиж, бизнесийн итгэл батжиж, гадаадын хөрөнгө оруулалт урамшиж, барааны эргэлт нэмэгдэнэ.
- Үндэсний эдийн засаг сэргэнэ.

Эрсдлийн менежментийг хэрэгжүүлнэ гэдэгт эрсдэл үүсэх, орчин, шалтгааныг эрт таньж мэдэх, илрүүлэн түвшинг тогтоох, эрсдэлд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр эрсдлийг багасгах, түүний эсрэг арга хэмжээ авах зэрэг ажлуудыг хамрааруулдаг. Эрсдлийн менежментийг хэрэгжүүлэх явцад эрсдэл хаанаас гарч ирж болохыг урьдчилан тогтоож, гаалийн хяналт шалгалтын хувьд эрсдэл дагуулж болох хүчин зүйлс, тухайлбал, гаалиар үйлчлүүлэгч байгууллага, аж ахуйн нэгж, хувь хүмүүсийн талаарх мэдээлэл, тэдний сайн болон сул талууд,

эрсдэл тэдний чухам хаанаас, хэнээс, хэзээ, гарч болох, тэрхүү эрсдэл нь гаалийн хяналт шалгалтын хувьд аль хэсэгт хэрхэн нөлөөлж болох, ямар тохиолдолд эдгээр зүйлс илүү эрсдэлтэй байж болохыг тогтоох нь чухал байна.

Өнөөдрийн гаалийн системийн хэмжээнд эрсдлийн менежмент үйл ажиллагаанд иж бүрэн нэвтрээгүй ч цаашид бүрдүүлэлтийг хялбарчлах ажилтай уялдуулан эрсдлээ зөв тооцсоны үндсэн дээр гаалийн хяналт шалгалтыг оновчтой зөв зохион байгуулснаар зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнийг таслан зогсоох, үйлчлүүлэгч нарт чирэгдэл багатай үйлчлэх юм. Эрсдлийн менежментийг бүх шатанд нэвтрүүлсний үр дүнд гаалийн байгууллагын боловсон хүчнийг зөв байршуулж хяналт шалгалт сайжрах, гаалийн бүрдүүлэлт болон хяналт шалгалтын шат дамжлагууд багасаж, харилцагч нарт шуурхай үйлчлэх боломжтой болно.

Гаалийн эрсдлийн менежментийн чухал бүрэлдэхүүн хэсэг бол гаалийн бүрдүүлэлтийг хялбарчлах, эрсдлийг тооцох явдал юм. Гаалийн тухай хууль болон түүнийг хэрэгжүүлэхээр гаргасан заавар журмыг байнга боловсронгуй болгох, бусад хууль тогтоомжуудтай уялдуулан нийцүүлэх бодлогын арга хэмжээ нь гаалийн үйл ажиллагааг хөнгөн шуурхай болгоход чиглэгддэг. Үүний тулд гаалийн бүрдүүлэлтийг хялбарчлах бүх боломжийг ашиглахдаа эрсдлийг зөв тодорхойлж, үр дүнг тооцож байх нь гаалийн байгууллагын чухал зорилт болж байна. Хялбарчлах гэдэгт гаалийн бүрдүүлэлтийг бага цагт үр дүнтэй явуулах аргыг цогцоор нь тодорхойлж түүнийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх явдал гэж ойлгож болно. Үүний тулд:

- ✓ Эрх зүйн зохицуулалтын хувьд анхаарч, засч залруулах ёстойг тодорхойлох
- ✓ Мэдээллийг шуурхай авах, боловсруулах түвшинг дээшлүүлэх
- ✓ Эрсдлийн судалгаа хийх боломж, чадварыг нэмэгдүүлэх
- ✓ Хяналт, шалгалтын ажил ямар байгааг тогтоож, чадварыг дээшлүүлэх
- ✓ Гаалийн улсын байцаагчийн мэдлэг, ажлын ур чадварт үнэлгээ дүгнэлт өгөх
- ✓ Гаалийн хууль тогтоомжийг сурталчлах
- ✓ Нэг талын болон хамтарсан үзлэг шалгалт хийх нөхцөл боломжийг бүрдүүлэх
- ✓ Хөрш орнуудын гаалийн хууль тогтоомжийн судалгааг тогтмол хийх
- ✓ Итгэлцлийн меморандум байгуулах боломж, нөхцөл байдлыг судалгаа, мэдээллийн үндсэн дээр бий болгох

- ✓ Хамтран ажилладаг даатгал, банк, зуучийн зэрэг байгууллагын ажлын уялдаа, мэдээллийг сайжруулах
- ✓ Бүрдүүлэлтийн дараах шалгалтын ач холбогдлыг өндөржүүлэх зэрэг арга хэмжээнүүдийг авах хэрэгтэй байна.

Эрсдлийг хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд ямар нэгэн сөрөг нөлөөнөөс үзүүлж болох үр дагавар, түүний хэмжээ нэмэгдэх магадлалыг хамруулдаг тул гаалийн эрсдлийг дотор нь дараах байдлаар ангилж болох юм. Үүнд:

Барааны эрсдэлд: бага үнээр мэдүүлэх, төлбөрийн баримт хуурамчаар үйлдэх, хуурамч гэрээ, баримт гаргах, онцгой албан татвараас зайлсхийх, нэмэлт зардлыг дутуу мэдүүлэх, татвар нь улирлын чанартай барааны хугацааг ашиглах, түр горимын хугацааг баримтлахгүй байх, бараагаар халхавчлах, нэг төрлийн доод зэрэглэлтэй бараагаар, бага үнэтэй бараагаар, олон барааг ижил савлагаатай бараагаар солих зэрэг

Үйл ажиллагааны эрсдэлд: жингийн зөрүү, даац, багтаамжаас хэт багаар мэдүүлэх, хил залгаа гаалийн статистикийн мэдээ зөрөх, мэдүүлж байсан гаалийн байгууллагаа өөрчлөх, баримтанд байх ёстой зүйлийн аль нэг нь байхгүй байх, бараа хүрэх газраа очоогүй байх, нэвтрүүлэх боломжоос хэт их бараа мэдүүлсэн байх, нэг төрлийн зөрчил давтагдах, анхааруулгатай барааны үзлэгийг дутуу хийх, татварын дүн буурсан байх, бага татвартай хэт олон мэдүүлгээр мэдүүлсэн байх, бичиг баримт удаа дараа дутаах, алга болгох зэрэг багтана.

Эрсдлийн талаар мэдээллийг цуглуулж боловсруулах нь удирдлагын стратеги зохиох явцад голлох үүрэгтэй. Гаалийн бодлогын төсөл зохиох ажлын чухал нэг шат бол улс төрийн шинжилгээ юм. Энэ шатны бүтэцэд:

- Олон улсын болон төрийн байгууллагад, хувь хүн, тэдгээрийн бодлого гаалийн бодлогыг бүрдүүлэх, түүнийг боловсруулж хэрэгжүүлэх процесст хэрхэн нөлөөлж улмаар тэд энэ процесст хэрхэн оролцож үйл ажиллагааны тодорхой асуудлууд, мотиваци зэрэгт яаж хандаж буй зэргийг шинжлэх
- Гаалийн бодлого болон түүнтэй холбоотой улс төрчдийн хоорондын харилцан хамаарал, хамтын ажиллагаа, зөрчил, төвийг сахих зэрэг харилцааг шинжлэх
- Бодлогыг хэрэгжүүлэхэд шаардлагатай үндсэн нөөц боломж болон тэдгээрийг үр дүнтэй ашиглах механизмуудыг тодорхойлох
- Улс орны нийгэм, дотоод эдийн засгийн хөгжил, гадаад эдийн засгийн харилцааны урьдчилан таамаглаж болох нөхцөл байдал, гаалийн салбар дахь харилцааны хөгжлийн дэлхийн хандлагыг шинжлэх
- Шийдвэр гаргах нийтлэг механизм, процессыг шинжлэх

- Гаалийн бодлогын альтернатив концепциудыг боловсруулж үнэлэлт дүгнэлт өгөх
- Тухайн улс орон болон дэлхий даяар бүрэлдсэн, урьдчилан таамаглах боломжтой улс төрийн нөхцөл байдал, нийгэм-эдийн засгийн орчиноос үүсэлтэй хязгаарлалтыг шинжлэх зэрэг болно.

Дээрх шинжилгээний дүнд гол асуудлуудыг тодорхойлж гаалийн бодлогын зорилтыг томъёолно. Дэвшүүлж болох альтернатив хувилбарыг сонгоно. Нөхцөл байдал, төлөв хандлагыг шинжилсэнээр бодлогын бүтэц байгууллага тус бүрт хандсан асуудлуудыг нарийвчлан тогтоож тэдгээрийн ач холбогдол, зайлшгүй яаралтай шийдэх шаардлагатай эсэх болон ямар түвшинд шийдвэрлээд байгаа зэргийг тодорхойлно. Мөн эрсдлийг урьдчилан тогтоосон шалгууруудын үндсэн дээр үнэлнэ. Шалгууруудын дагуу эрсдлийг үнэлэхдээ эрсдэл өндөр, дунд, бага гэж үнэлж болох боловч 1-100-ын дотор оноо өгч үнэлэх нь илүү найдвартай байдаг.

Гаалийн байгууллагын хэмжээнд эрсдлийн менежментийг хэрэгжүүлэх ажил нь стратегийн, үйл ажиллагааны болон тактикийн шинжтэй байвал зохино.

Стратегийн эрсдлийн менежмент гэдэг нь гааль ихээхэн хэмжээний мэдээллийг судалж, түүнээс эрсдэлтэй байж болох хүрээг тодорхойлох үйл явц юм. Гаалийн хувьд эрсдэлтэй байх болох хүрээнд хар тамхины хууль бус худалдаа, садар самууны сурталчилгаа, импорт, экспортын хориг, хязгаар, нийгмийн эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах, худалдааны бодлогын зарим асуудлууд, оюуны өмчийн эрхийн зөрчил, хөнгөлөлтийн ерөнхий зарчим, квот, гаалийн болон бусад татварын асуудлууд ордог.

Үйл ажиллагааны эрсдлийн менежментэд үнэлэлт өгсөн эрсдэлтэй холбогдсон гаалийн хяналтын үйл ажиллагааг удирдах асуудал хамаарна. Тухайлбал, аудитын шалгалтыг нэвтрүүлэх нь хүн хүчийг хэмнэж, хилээр нэвтэрч байгаа хөдөлгөөн болгоныг хянаж худалдаанд саад тотгор учруулахаас зайлсхийх, гаалийн хяналтын эрсдлийг зөв тодорхойлсоны үндсэн дээр эрсдэл өндөртэй барааны эргэлтэнд оновчтой хяналт тавих бололцоог олгодог.

Тактикийн эрсдлийн менежмент хяналт шалгалтын явцад эрсдэлтэй тулгарч шуурхай арга хэмжээ авах шаардлагатай болсон гаалийн улсын байцаагч нар хэрэглэдэг ба тэд цуглуулсан мэдээлэлд дүн шинжилгээ хийж, өөрийн туршлага, мэргэжлийн ур чадвартаа тулгуурлан хилээр нэвтэрч байгаа бараа, тээврийн хэрэгслийн аль өндөр эрсдэлтэйг нь таньж сонгон шалгаруулна.

Гаалийн эрсдлийн менежментийг бий болгох, түүнийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд гаалийн бүрдүүлэлтийг хөнгөн шуурхай болгох, хялбарчлах, гаалийн хяналт шалгалтыг эрсдэл тооцсоны үндсэн дээр богино хугацаанд, бага зардлаар оновчтой, үр дүнтэй явуулах, гаалийн хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх,

түүнийг илрүүлэх, үйлчлүүлэгч нарт итгэл үзүүлэх зорилгоор гаалийн мэдээллийн “Эрсдлийн программ”-ыг боловсруулан туршиж эхлэлээ.

Гаалийн мэдээллийн “Эрсдлийн программ” нь дараах мэдээллийн сангаас бүрдэж байна. Үүнд:

- Бүрдүүлэлтийн дараах шалгалтын мэдээллийн сан
- Захиргааны зөрчлийн талаарх мэдээллийн сан
- Шинээр бүртгэгдсэн аж ахуйн нэгж, байгууллагын бүртгэлийн сан
- Эрсдэлтэй барааны сан
- Гаалийн үнийн дээд, доод хязгаарын сан
- Гадаад тээврийн зардлын үнийн мэдээллийн сан
- Гаалийн бүрдүүлэлт хийгдсэн аж ахуйн нэгж, байгууллага, иргэний өр, авлагын талаарх мэдээллийн сан
- Гадаадын болон Монголын бараа, тээврийн хэрэгслийг улсын хилээр түр хугацаагаар оруулах, гаргахад хяналт тавих мэдээллийн сан
- Засгийн газар, банк, даатгалын байгууллагын шийдвэр, баталгаа, барьцааны гэрээгээр хойшлогдсон татварын мэдээллийн сан
- Манифестын мэдээллийн баазын мэдээллийг эрсдлийн программтай холбож хяналт тавих сан
- Мэдрэмж буюу “Байцаагчийн дүгнэлт”
- Эрсдлийн программ өөрөө санамсаргүйгээр түүвэрлэн шалгах сан
- Хяналт шалгалтын хэлтсийн дарга бүрдүүлэлтийн талаарх мэдээг гаргах сан

Эрсдлийн менежмент нэвтрүүлэхэд анхаарах зүйлс, алхамууд

Эрсдлийн менежментийн үйл ажиллагааг нэвтрүүлэх үүднээс гаалийн горимыг хялбарчлах, уялдуулах тухай олон улсын Конвенцитай холбогдуулан эрсдлийн менежментийг хөгжүүлэх талаар ДГБ-ын нарийн бичгийн дарга нарын газар болон түүний гишүүн улсууд өнөөдрийг хүртэл дэс дараатай олон арга хэмжээ авч хэрэгжүүлж ирлээ. Жишээлбэл: хууль тогтоомжийн зөрчилтэй тэмцэх ажлын хүрээнд зорчигч болон барааны хөдөлгөөнийг авч үзэн, цэвэр техникийн чанартай “эрсдлийн тооцох, тодорхойлох, онилох” систем боловсруулжээ. Эдгээр нь үнэхээр үнэ цэнэтэй анхны алхамууд мөн бөгөөд эрсдлийн менежментийн

систем амжилттай хэрэгжих үндэс суурь болж өгч байна. Гэвч эрсдлийн менежмент нь зөвхөн хэдхэн тооны ажлаар хязгаарлагдах биш гаалийн ажлын бүх талыг хамарсан өргөн хүрээний үйл ажиллагаа юм. Гаалийн байгууллагад эрсдлийн менежментийг нэвтрүүлэхэд дараах зүйлүүдийг анхаарах хэрэгтэй юм. Үүнд:

Стратегийн төлөвлөгөөнд зохицуулалт хийх, мониторинг явуулах

Менежментийн болон стратегийн төлөвлөгөөнд дэд бүтцийн холбогдох өөрчлөлтүүдийг тусгаж, уг төлөвлөгөөг хэрэгжүүлэх үе шатуудыг нарийвчлан тогтоох шаардлагатай. Харин удирдлагууд эрсдлийн менежментийн систем, шинэ санаачилгууд хэрхэн хэрэгжиж буйг алхам бүр хянаж, тодорхой хугацааны турш өмнөх байдалтай харьцуулсан дүгнэлт хийж, тайлагнана.

Мэдээлийн нууцлалыг өндөржүүлэх

Эрсдлийн менежментийг олон улсын тухайн уур амьсгалд зохицуулан эрчимтэй хэрэгжүүлэх үүднээс гаалийн байгууллага импорлогч, экспортлогч, гаалийн зуучлагч, тээвэрлэгч болон бусад албадтай нягт холбоотой байж, бараа зорчигчийн талаар хэрэгцээтэй мэдээлэл авах, гадаад худалдааны мэдээлэлд нэвтрэх боломжоо хянан үзэж, үр дүнг тооцож байх шаардлагатай. Гаалийн байгууллага үндэсний аюулгүй байдлын стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд идэвхитэй оролцож, эрсдлийн менежментийн үр нөлөөтэй стратеги боловсруулах явдал чухал юм.

Боловсон хүчний хөдөлгөөн, удирдах аргын өөрчлөлт

Эрсдлийн менежмент нэвтрүүлэхэд гаалийн удирдлагын арга хөндөгдөх учир гаалийн бүх салбарын боловсон хүчний хувиарлалтанд өөрчлөлт орно. Бодлого боловсруулах түвшиний ахлах мэргэжилтнүүд эрсдлийн менежмент нэвтрүүлсэнээр үндсээрээ өөрчлөгдсөн шинэ үйл ажиллагааг удирдан зохион байгуулах шаардлага тулгарна. Гол гол боомтуудад ажилладаг боловсон хүчний хуваарилалтыг эргэн харж бүс нутгийн удирдлагын системийг мөн зохицуулан өөрчлөх шаардлагатай. Ажилтнууд ямар нэг шинэ зүйлийг тэр болгон нааштайгаар хүлээж авдаггүй гэдгийг урьдчилан тооцох хэрэгтэй.

Туслах үйлчилгээ

Эрсдэлийн менежментийн хөтөлбөрийг үр ашигтай хэрэгжүүлэхийн тулд мэдээллийн технологи, дэд бүтэц, сургалт зэрэг туслах үйлчилгээний хэлбэрүүдийг бас тооцож үзэх юм. Эдгээр албанд нь гаалийн үйлчилгээг эрсдлийн менежментийн стратеги төлөвлөгөөний хүрээнд, мөн гүйцэтгэлийн хэмжээнд тодотгон, сайжруулахад чухал үүрэг гүйцэтгэнэ.

Бизнесийн хүрээний үүрэг, роль

Дээрх өөрчлөлтүүд зөвхөн шударга бизнесийн идэвхитэй оролцоотойгоор амжилттай хэрэгжих нь улам бүр тодорхой болж байна. Түншлэлийн арга хэлбэрийг зөөлөн сонголт гэж үздэг үзэл үгүй болно. Хэрэг дээрээ үүний үр дүнд бид арилжааны үйл ажиллагааны талаар тодорхой мэдлэг олж авч, түүнд түшиглэн хяналт, шалгалтыг илүү үр ашигтай, илүү үр нөлөөтэй явуулах болно. Ингэснээр эрсдэл өндөртэй бараа, зорчигчийг онилон шалгах юм. Бизнесийн талаас нь авч үзвэл гаалийн горимыг хялбарчлах замаар хувль ёсны худалдааны бүрдүүлэлт шуурхай, саадгүй болно.

Ашигласан хэвлэл

1. Баярсайхан Д. "Гаалийн эрсдлийн менежмент" УБ., 2004 он.
2. Гаалийн горимыг хялбарчлах, уялдуулах тухай олон улсын конвенци (Шинэчилэн найруулсан Киотогийн конвенци, 1990)
3. Гаалийн мэдээлэл, 2000-2004 он.
4. Лхаашид Д. Менежментийн үндэс, 74., 1998 он.
5. Шуурав Я. "Менежмент" УБ., 1997 он
6. Ершов А.Д. Основы управления и организации в таможенном деле. Учебное пособие. Санкт-Петербург, 1999
7. Материалы форума "Реформа и модернизация таможни". ВТО\СТС, Брюссель, апрель 1997.
8. Risk Management Guide, WCO, June 20036
9. Risk Management Australian \New Zealand Stanand (AS\NZS 4360: 1995)